



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2021/1/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2021 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: Bolort@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	3-6
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	7
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	8
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	9-10
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.	Аудитын тайлан	13
3.1	Ерөнхий зүйл	13-14
3.2	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13-14
3.3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13-16
3.4	Материаллаг байдал	16
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	16
3.5.1	Мөнгөн хөрөнгө	16-17
3.5.2	Авлага	17-19
3.5.3	Урьдчилгаа	19-20
3.5.4	Бараа материал	20-21
3.5.5	Нөөц хөрөнгө	21
3.5.6	Үндсэн хөрөнгө	21-23
3.5.7	Өр төлбөр	24-25
3.5.8	Засгийн газрын хувь оролцоо	25-27
3.5.9	Орлогын данс	27-28
3.5.10	Зардлын данс	28-29
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	30-33
3.7	Шилэн дансны мэдээлэл	33-34
3.8	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	34
3.9	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	35-40
3.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	40-41
4.	Менежментийн захидал	41-42
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	43-44

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СТСХ	Санхүүгийн төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭДДҮТТ	Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮЦСАА	Үржлийн цөм сүргийн аж ахуй
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1. Аудитын гэрчилгээ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2021.04.20 № СЭА-2021/1/СТА-ТЭЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ш.ОРГИЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

СЭА-2021/1/СТА-ТЭЗ

3

018020424

Аудитын гол асуудал

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Шаамар сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Сөрөг”, 5 төвлөрүүлэн захирагч, 5 шууд захирагч, орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж зэрэг 21 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, орон нутгийн өмчит “ТЭДДҮТ” үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.
- Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг 210.0 сая төгрөгөөр, ОНХО-ыг 234.0 сая төгрөгөөр, Замын сангийн хөрөнгө оруулалтыг 62.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, хуулиар хуулиар тогтоосон хувь хэмжээгээр хэрэгждэг БХНСАХ-ний зардлыг 238.0 сая төгрөгөөр бууруулахаар зэрэг хууль, эрх зүйн актыг зөрчсөн тодотгол хийсэн,
- ХХОАТ-ын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр 2,227.8 сая төгрөгөөр нэмж тодотгосноос аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2,534.4 сая төгрөгөөр тасалсан,
- Шууд худалдан авах босго үнээс давсан 12 байгууллага, аж ахуйн нэгжийн 580.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- ИТХ-д суудалтай намуудын санхүүгийн дэмжлэгт 180.0 сая төгрөг баталж, хэрэгжүүлсэн,
- Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас 4.6 сая төгрөгийн гадаад томилолтын зардал, ЗДНХ-өөс аймгийн ЗДТГ-ын урсгал үйл ажиллагаанд 10.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, ЗДҮАХ-ийн зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй 38.6 сая төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сурталчилж, тайлагнасан 33.5 сая төгрөгийн “Он дарааллын бичээс” сэтгүүл болон Ковид-19 цар тахалтай холбогдуулан аймгийн Онцгой комисст иргэд, ААНБ-аас өгсөн 26.4 сая төгрөгийн хандивыг бүртгэл, тайланд тусгаагүй,
- Мандал сумын Билэг ДБ хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр бус батлагдсан төсвөөр тооцон 60.4 сая төгрөг илүү олгосон,
- Биений тамир, спортын байгууллагуудын өөрийн орлогыг санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгаагүйгээс системийн хэмжээгээр төвлөрсөн 28.1 сая төгрөгийн өөрийн орлогыг байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, урсгал зардалд зарцуулах эрх олгосон,
- ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 0.7-1,475.4 сая төгрөгийн, нийт 4,433.7 сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдаж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадаагүй,
- Сэлэнгэ орон сууц үйлдвэрийн газар нь сарын хуваарьт орон сууцны төлбөрийн 52.1 сая төгрөг, Сүхбаатар хөгжил тохижилт үйлдвэрийн газар нь лангууны

түрээсийн 13.2 сая төгрөг, нийт 65.3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн боловч гэрээний дагуу арга хэмжээ аваагүй,

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 21 байгууллага 27.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн, 8 байгууллага 20.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүссэн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй,
- Төсвийг зохистой удирдаагүй ба төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 13 байгууллага 43.8 сая төгрөгийн төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, өмнөх оны санхүүгийн тайланд тусгаадаагүй 6 байгууллагын 7.9 сая төгрөгийн өр төлбөрийг тайлант оны төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан,
- Хушаат сум бэлчээрийн төлбөрийн орлого 12.6 сая төгрөгийг Мөнх толгойн хөгжил, Даагат хөгжил сангийн дансаар, Сант сум хадлангийн төлбөрийн орлого 1.2 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан,
- Орон нутгийн төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах тухай сумын ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр 4 сум нийт 43.7 сая төгрөгийг зарцуулсан,
- Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр 47 байгууллага 124.0 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, 13 байгууллага 50.6 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэргүйгээр буюу давхардуулан олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон зэргээр 82 байгууллага 98.0 сая төгрөгийн зөрчил гаргасан,
- Батлагдсан орон тоог хэтрүүлж 6 байгууллага 21.1 сая төгрөгийн цалин олгосон,
- Эмийн батлагдсан төсөв хэтрүүлсэн, эм дутагдуулсан, дутагдсан эмийг зардалд тайлагнасан, эмийн борлуулалтын орлогыг дутуу төвлөрүүлсэн, хэрэгцээнээс илүү эм нөөцөлсөн зэргээр 11 сумын эрүүл мэндийн төв нийт 81.3 сая төгрөгийн зөрчил гаргасан,
- Аймгийн ТЕЗ нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 103 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс дотоод аудитын хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагч батлаагүй, хяналт шалгалтын дүнг "Дотоод аудитын хороо"-нд тайлагнуулж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 34 дүгээр зүйлийн 34.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Боловсролын тухай хуулийн 40.2, ТБОНӨ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, ТБОНӨХБАУХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.8, 6.10, Засгийн газрын

2013 оны 68 дугаар тогтоолын 1, 2, 2015 оны 483 дугаар тогтоолын 7.6.1, 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 3.12, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,907.0	46,133.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,034.7	12,801.3
33	АВЛАГА	13,726.2	15,386.1
34	УРЬДЧИЛГАА	3,563.0	7,214.7
35	БАРАА МАТЕРИАЛ	14,574.9	10,726.0
36	НӨӨЦИЙН БАРАА	8.2	5.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	242,471.0	257,480.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	242,471.0	257,480.0
39200	Биет хөрөнгө	224,341.2	239,264.6
39300	Биет бус хөрөнгө	18,129.8	18,215.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	280,378.0	303,613.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,829.4	21,797.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,585.1	20,441.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	394.8	394.8
41300	Өглөг	13,401.1	17,161.7
41400	Урьдчилж орсон орлого	1,789.2	2,885.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	244.3	1,355.3
42200	Урт хугацаат зээл	244.3	1,355.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	264,548.6	281,816.8
51	Засгийн газрын хувь оролцоо	264,548.6	281,816.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,503.3	82,004.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	527.6	2,600.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	993.1	6,579.1
51200	Хуримтлагдсан үр дүн	46,209.5	63,662.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,315.1	126,970.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	280,378.0	303,613.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	205,166.7	141,949.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	19,548.3	27,296.8
110	Орлогын албан татвар	14,407.6	15,526.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	15,538.9	16,494.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,131.3	-968.0
113	Хөрөнгийн албан татвар	1,610.9	2,057.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,529.8	9,712.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,711.5	99,739.9
120	Нийтлэг татварын бус орлого	22,794.5	30,536.9
121	Хөрөнгийн орлого	23.3	82.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	55,893.7	69,120.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,906.9	14,912.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	181,565.2	103,011.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,981.6	103,011.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,275.3	95,292.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,795.3	50,883.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,413.9	6,454.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,070.6	8,447.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,830.1	2,259.2
2105	Нормативт зардал	3,650.3	4,209.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.1	989.8
2107	Томилолт, зочны зардал	445.4	249.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,409.6	4,624.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,660.0	17,173.2
212	ТАТААС	517.3	338.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,189.0	7,380.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	583.6	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	23,601.5	38,938.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1.1	307.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,438.5	22,204.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,164.2	17,041.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	199,228.0	126,659.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	19,548.3	27,299.0
110	Орлогын албан татвар	14,407.6	15,528.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	15,538.9	16,496.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,131.3	-968.0
113	Хөрөнгийн албан татвар	1,610.9	2,057.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,529.8	9,712.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	837.7	966.5
1181	Газрын төлбөр	1,003.8	1,340.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,688.3	7,405.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,566.9	84,533.3
120	Нийтлэг татварын бус орлого	13,649.9	15,330.4
121	Хөрөнгийн орлого	23.3	82.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	55,893.7	69,120.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,112.8	14,827.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,900.9	102,077.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,900.9	102,077.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,088.3	94,337.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,508.0	54,762.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,174.8	6,808.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,458.1	10,103.5
2104	Хангамж, бараа материалын зардал	4,352.5	5,155.3
2105	Нормативт зардал	3,830.1	4,146.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,009.7	1,006.1
2107	Томилолт, зочны зардал	443.9	247.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,459.1	5,134.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,852.1	6,972.7
212	ТАТААС	517.4	338.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,295.2	7,401.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,327.1	24,582.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	3.7	84.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,586.6	17,061.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,586.6	17,061.3
2200	Дотоод эх үүсвэрээр	18,586.6	17,061.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-18,582.9	-16,977.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,026.4	-838.3
14	Бусад эх үүсвэр	24.0	16.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	938.2	686.2

25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	112.1	168.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,717.8	6,766.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,316.9	6,034.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,034.7	12,801.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,153.0	252,153.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	244.7	244.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,397.7	252,397.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-212.5	-212.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	99.6	99.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	99.7	99.7
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	12,164.2	12,164.2
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,548.6	264,548.6
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	264,548.6	264,548.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	679.1	679.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,227.7	265,227.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-336.1	-336.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	-116.5	-116.5
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	17,041.7	17,041.7
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	281,816.8	281,816.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,550.6	91,576.6	-12,974.0	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,292.0	82,188.2	-7,103.8	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,648.6	80,233.5	-6,415.1	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,854.7	50,599.1	-1,255.6	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,959.3	6,448.5	-510.8	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,692.8	8,600.1	-1,092.7	88.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,779.5	1,684.3	-95.2	94.7
2105	Нормативт зардал	5,374.3	3,189.5	-2,184.8	59.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,568.1	2,340.8	-227.3	91.1
2107	Томилолт, зочны зардал	295.4	239.5	-55.9	81.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,782.9	2,493.1	-289.8	89.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,341.6	4,638.6	-703.0	86.8
212	ТАТААС	432.0	420.6	-11.4	97.4
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	60.0	60.0	0.0	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	372.0	360.6	-11.4	96.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,211.4	1,534.1	-677.3	69.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180.0	180.0	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,031.4	1,354.1	-677.3	66.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,355.8	8,702.3	-4,653.5	65.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,902.9	686.1	-1,216.8	36.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	104,550.6	93,770.8	-10,779.8	89.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,121.7	52,057.8	-4,063.9	92.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,526.9	39,272.7	-3,254.2	92.3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	590.9	440.1	-150.8	74.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,116.5	2,000.2	-2,116.3	48.6
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	860.0	0.0	-860.0	0.0
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	334.6	0.0	-334.6	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,404.6	1,404.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	3,598.8	3,598.8	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	37,093.0	90,156.0	53,063.0	243.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	194	192	-2	99.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4,452	4,387	-65	98.5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	27,995	26,491	-1,504	94.6
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	20,247	20,020	-227	98.9
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	7,748	6,471	-1,277	83.5
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	0	54,699	54,699	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,452	4,387	-65	98.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Зарцуулах эрх	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,875.5	5,875.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,431.2	5,431.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,359.3	3,359.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263.6	263.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16.1	16.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19.5	19.5
2104	Хангамж, бараа материалын зардал	96.1	96.1
2105	Нормативт зардал	959.0	959.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	198.2	198.1
2107	Томилолт, зочны зардал	7.7	7.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	377.2	377.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,421.9	1,421.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,071.9	2,071.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,709.1	1,709.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	362.8	362.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	444.3	444.3
2200	Дотоод эх үүсвэрээр	444.3	444.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,875.5	5,875.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,875.5	5,875.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0	0.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.1

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч /цаашид Сэлэнгэ аймгийн ТЕЗ гэх/-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга Ш.Оргил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ОНӨААТҮГ-ийн үр дүн, бараа материалын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 2021 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэн, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор, аудитор Д.Чулуунцэцэг, О.Анхбаяр, Т.Одсүрэн, З.Золбоо, Т.Мөнхзул нар гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/300 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Иргэдийнхээ хөгжил, айл өрхийн амьдралын чанарыг дээшлүүлж, Сэлэнгэ сайхан нутгаа хамтын хүчээр хөгжүүлцгээе” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах;
- Нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сэлэнгэ аймгийн ТЕЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус ТЕЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/202 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шинэчлэн боловсруулсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль, тогтоомжтой нийцсэн байна.

ТЕЗ-ийн дотоод хяналтын үр нөлөөг төлөвлөлтийн шатанд хангалтгүй гэж тооцсон бөгөөд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д *“Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”* гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Тус алба нь тайлант онд их, дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 30 байгууллагад дотоод аудит, 55 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 18 байгууллагад дотоод хяналт, 43 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэн, тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн орлого бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, ил тод байдалд хийсэн хяналт шалгалтаар нийт **322.3** сая төгрөгийн 185 зөрчил илрүүлж, **39.7** сая төгрөгийн 14 төлбөрийн акт тогтоон, **282.6** сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгуулах, засаж залруулах 115 зөвлөмж өгсөн гэж тайлагнасан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т *“Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч батална”* гэж заасан атал аудитын хяналт, шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулдаггүй зөрчил оршсоор байна.

Санхүүгийн хяналтын албанаас 2020 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн хяналт, шалгалтын төлөвлөгөө нь эрсдэлд суурилагагүй, тодорхой сэдэвт чиглээгүй бөгөөд хяналт шалгалтын дүнд Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах болон СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан, холбогдох тодруулгыг бэлтгэх, худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэх зэрэг хэт ерөнхий зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Өөрөөр хэлбэл Санхүүгийн хяналт, аудитын алба нь эрсдэлд үндэслэсэн хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр нөлөө бүхий зөвлөмж өгч, хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүйгээс Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас харьяа байгууллагуудын жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлдэг батлагдсан төсвийг зориулалт бусаар, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулдаг, цалин, урамшууллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн давхардуулан олгодог, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэдэг, худалдан авах ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд холбогдох хууль журмыг бүрэн хэрэгжүүлдэггүй гэх мэт зөрчлүүд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар ч материаллаг хэмжээгээр илэрсэн байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 9 дүгээр тогтоолоор Санхүүгийн хяналт аудитын албаны төлөвлөгөөг батлах, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын хийсэн аудитын үйл ажиллагааны тайланг

хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах “Дотоод хяналтын хороо”-г нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.10 дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдээ Дотоод аудитын хороотой байж болох бөгөөд хороог тухайн төсвийн ерөнхийлөн захирагч даргална”, 4.14 дэх “...Хороо нь **сондгой тооны гишүүдтэй** байна.” гэж заасныг зөрчсөн байна.

Цаашид тус хороог холбогдох дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулж, Санхүүгийн хяналт аудитын албанаас хийсэн аудитын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч ажилласнаар дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 181,565.2 сая төгрөгөөс 1 хувиар тооцон **1,815.6** сая төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу **1,033.2** сая төгрөг болгон өөрчилсөн болно.

3.5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 6,034.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 12,801.3 сая төгрөг болж, 6,766.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	18.6	6.2	(12.4)	200
Банканд байгаа бэлэн мөнгө	6,016.1	12,795.1	6,779.0	53.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	6,034.7	12,801.3	6,766.6	52.9
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	1,332.4	3,520.4	2,188.0	62.2
Төсөл / сан	2,224.0	2,885.2	661.2	22.9
Төрийн сан	2,034.4	5,700.9	3,666.5	64.3
ОНӨААТҮГ	443.9	694.8	250.9	36.1
Дүн	6,034.7	12,801.3	6,766.6	52.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 12,795.1 сая төгрөгийн үлдэгдлийн 27.5 хувийг төсөвт байгууллагын, 5.4 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, 22.5 хувийг төсөл, сангийн, 44.6 хувийг төрийн сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,590.8 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 12,106.5 сая төгрөг болж, 6,515.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/
				Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	5,590.8	12,106.5	6,515.7	53.8
Төрийн сан	5,590.7	12,106.3	6,515.6	53.8
Монгол банк				
Арилжааны банк	0.1	0.2	0.1	50.0
Гадаад валют				
Монгол банк				
Замд яваа хөрөнгө				
Дүн	5,590.8	12,106.5	6,515.7	53.8

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 347.2 сая төгрөгийг орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд, 111.6 сая төгрөгийг өмнөх оны татаас санхүүжилтийн өглөгт, 43.8 сая төгрөгийг он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд, 391.4 сая төгрөгийг Сум хөгжүүлэх сангаас зээл олгоход тус тус зарцуулсан байна.

Тайлант онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 5,259.6 сая төгрөг, ОНХС-аас 7,739.5 сая төгрөг, БШУЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 47,594.7 сая төгрөг, ЭМЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 7,495.6 сая төгрөг, БХБЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 596.2 сая төгрөг, ХНХЯ-аас 435.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлого 30,019.3 сая төгрөг, орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого 1,994.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого 6.5 сая төгрөг зэрэг нийт 101,141.2 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрч, 87,654.7 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 7,739.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 700.2 сая төгрөгийг СХС-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 13,726.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 15,386.1 сая төгрөг болж 1,659.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	62.2	54.6	(7.6)
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.1	0.0	(0.1)

Татаас, санхүүжилтийн авлага	188.9	6.6	(182.3)
Зээлийн хүүгийн авлага	296.7	278.4	(18.3)
Дансны авлага /ОНӨААТҮГ/	1,437.4	1,730.0	292.6
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨААТҮГ/	89.6	18.5	(71.1)
Бусад авлага	6,502.2	8,294.5	1,792.3
Зээлийн авлага	5,149.1	5,003.5	(145.6)
Дүн	13,726.2	15,386.1	1,659.9
Үүнээс: Байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	5,838.3	7,648.3	1,810.0
Төсөл/ сан	144.8	135.8	(9.0)
Төрийн сан	389.8	368.7	(21.1)
ОНӨААТҮГ	7,353.3	7,233.3	(120.0)
Дүн	13,726.2	15,386.1	1,659.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 17.9 хувийг буюу 2,761.1 сая төгрөгийг “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ, 10.0 хувь буюу 1,544.3 сая төгрөгийг “Гавшгай ус” ХХК, 9.0 хувь буюу 1,384.1 сая төгрөгийг “Урсгал ус” ХХК, 7.6 хувь буюу 1,162.0 сая төгрөгийг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /3-аас дээш жилийн/ нийт 6,183.1 сая төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын хувь хүмүүсээс авах 77.3 сая төгрөг,
- Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын байгууллагаас авах 1,578.8 сая төгрөг,
- ОНӨААТҮГ-ын дансны авлага 1,196.2 сая төгрөг,
- СХС-аас олгосон зээлийн 3,105.7 сая төгрөгийн, зээлийн хүүгийн 196.7 сая төгрөг,
- Төсөвт байгууллагын ажиллагчидтай холбогдсон 23.7 сая төгрөг, татаас, санхүүжилтийн 4.2 сая төгрөг, татвар, НДШ-ийн 0.5 сая төгрөгийн авлагууд байна.

Олон жилийн насжилттай хувь хүмүүсээс авах авлагын 35.8 хувь буюу 27.7 сая төгрөгийг 2008, 2009, 2011 онуудад олгосон итгэлийн зээлийн авлага, 64.2 хувь буюу 49.6 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын авлага эзэлж байна.

Олон жилийн насжилттай байгууллагаас авах авлагын 85.8 хувь буюу 1,354.7 сая төгрөгийг Гавшгай-Ус ХХК-ийн, 4.3 хувь буюу 69.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн, 3.5 хувь буюу 54.5 сая төгрөгийг Цант-Орхон ХХК-ийн авлага эзэлж байгаа бол 29 төсөвт байгууллагуудын 100.4 сая төгрөгийн авлага нь 6.4 хувийг эзэлж байна.

Дээрх олон жилийн насжилттай авлагуудын зарим эзэн холбогдогчид нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхойгүйгээс шүүхэд хандах боломжгүй бол зарим нь хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон найдваргүй авлагууд байна.

Олон жилийн насжилттай авлагын 50.2 хувь буюу 3,105.7 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангаас 2011-2016 онуудад олгосон зээлийн, 3.1 хувь буюу 196.7 сая төгрөг нь зээлийн хүүгийн авлага байна.

СХС-ийн зээлийн эргэн төлөлт бүрэн хийгдэхгүйгээс сангийн эх үүсвэр нөхөн бүрдэхгүй байх, албан хаагчидтай холбоотой авлага нь найдваргүй авлагад шилжих, төсвийн хөрөнгө үрэгдэх эрсдэл, үр дагаврыг бий болгож байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой нийт 48.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
/Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 21 байгууллага **27.9** сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- 8 байгууллага **20.7** сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүссэн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 3,563.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 7,214.7 сая төгрөг болж, 3,651.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,563.0	7,214.7	3,651.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
Дүн	3,563.0	7,214.7	3,651.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2.0	1,690.8	1,688.8
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨААТҮГ	3,561.0	5,523.9	1,962.9
Дүн	3,563.0	7,214.7	3,651.7

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь төрийн албан хаагчдын 120 айлын орон сууцны төслийн зардалд 1,961.0 сая төгрөгийг хуримтлуулан бүртгэсэн болон Ковид-19 цар тахлын улмаас тендер шалгаруулалт, гүйцэтгэлийн ажил удааширч ОНХС-ийн 12 ажлын 508.6 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 6 ажлын 1,008.8 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 8 ажлын 171.0 сая төгрөгийг тус тус барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь төрийн албан хаагчдын орон сууцны барилгыг улсын комиссын актаар хүлээн авсны дараа зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах бөгөөд 2018 онд 406.7 сая төгрөг, 2019 онд 3,142.8 сая төгрөг, 2020 онд 1,961.0 зэрэг нийт 5,510.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал гаргасан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 14,574.9 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 10,726.0 сая төгрөг болж, 3,848.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	662.8	747.4	84.6
Эм боох материал	212.8	409.2	196.4
Дуусаагүй үйлдвэрлэл	6.5	47.8	41.3
Бэлэн бүтээгдэхүүн	105.5	125.8	20.3
Бичиг хэргийн материал	224.3	190.0	(34.3)
Аж ахуйн материал	3,177.9	3,610.9	433.0
Сэлбэг хэрэгсэл	1,244.3	1,055.7	(188.6)
Түлш, шатах тослох материал	22.9	45.4	22.5
Барилгын засварын материал	114.5	190.0	75.5
Хүнсний материал	142.3	62.6	(79.7)
Бусад хангамжийн материал	8,598.9	4,190.4	(4,408.5)
Мал амьтад	62.2	50.8	(11.4)
Дүн	14,574.9	10,726.0	(3,848.9)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	12,741.7	8,993.6	(3,748.1)
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨААТҮГ	1,833.2	1,732.4	(100.8)
Дүн	14,574.9	10,726.0	(3,848.9)

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 3,848.9 сая төгрөгөөр буурсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн Баянгол суманд 1,6 км бетон хучилттай зам тавих, Орхон суманд инженерийн нэгдсэн шугам сүлжээ байгуулах, Сайханы хөтөлд шилэн гүүр цогцолборын тохижилт, зураг төслийн ажил, аймгийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн цогц систем суурилуулах, Орхон сумын "Атар-60" цогцолборын тохижилт зэрэг ажлын нийт 219,1 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хийгдсэн Дулаанхаан тосгоны захирагчийн албаны барилгын 361,1 сая төгрөг, эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Түшиг сумын сургуулийн дотуур байр барих, Орхонтуул сумын 1-р сургуулийн их засвар, Бугант тосгоны соёл спортын цогцолборын барилга барих ажлуудын, Бугант тосгоны цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлын 3,828.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжсэнийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Мөн 2017 онд аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 9.4 сая төгрөгийн авто зогсоолын ажлыг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой нийт 17.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Оны эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр Мандал сумын Ойн анги, аймгийн ИТХ нь нийт **7.0** сая төгрөгийн шатахуун авч нөөцөлсөн,
- Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ нь оны эхэнд 122,7 сая төгрөгийн өртөг бүхий ул ширэмний үлдэгдэлтэй, тайлант онд зарцуулалт гараагүй, шаардлага үүсээгүй байхад Жуулчин Сэлэнгэ компаниас нэмж **10.0** сая төгрөгийн ул ширэм худалдан авч / 2019 оны эхэнд 77.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, нэмж 45.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн боловч мөн зарцуулалтын гүйлгээ гараагүй / оны эцэст 132,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан буюу үйлдвэрлэлд тогтмол ашиглагдахгүй бүтээгдэхүүнийг хэрэгцээнээс илүү худалдан авч нөөцлөн хөрөнгийн эргэлтийг удаашруулж байна.

3.5.5 Нөөцийн бараа

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 8.1 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5.7 сая төгрөг болж, 2.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нөөцийн барааны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	2.3	0.0	(2.3)
Бусад нөөц	5.8	5.7	(0.1)
Дүн	8.1	5.7	(2.4)

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь Сүхбаатар сумын халаалт, дулааны тогтвортой байдлыг хангах, гэнэтийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 5.7 сая төгрөгийн барилгын засвар, шатахууны материалын үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 242,471.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл хөрөнгийн эхний үлдэгдэл 242,471.09.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	224,341.2	239,264.6	14,923.4

Барилга, байгууламж, орон сууц	191,003.7	211,554.2	20,550.5
Хуримтлагдсан элэгдэл	(10,742.5)	(17,013.0)	(6,270.5)
Авто тээврийн хэрэгсэл	7,944.3	9,117.0	1,172.7
Хуримтлагдсан элэгдэл	(4,911.5)	(5,448.1)	(536.6)
Машин тоног төхөөрөмж	18,381.1	19,660.1	1,279.0
Хуримтлагдсан элэгдэл	(11,139.1)	(11,834.0)	(694.9)
Тавилга, аж ахуйн эд хогшил	8,104.6	8,675.8	571.2
Хуримтлагдсан элэгдэл	(4,356.5)	(4,640.4)	(283.9)
Зам, гүүрний байгууламж	8,268.5	8,016.7	(251.8)
Хуримтлагдсан элэгдэл	(2,433.8)	(3,016.9)	(583.1)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,031.9	2,046.0	14.1
Бусад үндсэн хөрөнгө	21,063.9	23,015.6	1,951.7
Хуримтлагдсан элэгдэл	(4,774.7)	(7,059.2)	(2,284.5)
Дуусаагүй барилга, байгууламж	4,629.4	4,889.1	259.7
Ном	1,271.9	1,301.7	29.8
Биет бус хөрөнгө	18,129.8	18,215.4	85.6
Программ хангамж	178.3	267.9	89.6
Хуримтлагдсан элэгдэл	(112.1)	(133.4)	(21.3)
Бусад биет бус хөрөнгө	18,095.6	18,116.1	20.5
Хуримтлагдсан элэгдэл	(32.0)	(35.2)	(3.2)
Дүн	242,471.0	257,480.0	15,009.0
Үүнээс: Байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	170,104.3	182,225.5	12,121.2
Төсөл/ сан	0.6	2.8	2.2
Төрийн сан			0.0
ОНӨААТҮГ	72,366.1	75,251.7	2,885.6
Дүн	242,471.0	257,480.0	15,009.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,805.8 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 17,994.3 сая төгрөг, хандиваар нийлүүлэгдсэн 5,060.3 сая төгрөг, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдсэн 16,487.9 сая төгрөг зэрэг нийт **42,348.3** сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол балансаас баланст шилжүүлсэн 14,228.9 сая төгрөг, акталсан 2,074.1 сая төгрөг, улсын комиссын актаар 357.8 сая төгрөгийн хөрөнгийг хүлээж авч дуусаагүй барилгын үлдэгдлийг бууруулсан, дахин үнэлгээний хорогдол 0.4 сая төгрөг зэрэг нийт **16,661.2** сая төгрөгөөр буурсан байна.

Дуусаагүй барилга дансанд ОНХС-ийн болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн гүйцэтгэгч талын баримтын бүрдэл дутуу, ажил бүрэн хийгдээгүй зэргээс комиссын актаар хүлээн аваагүй дараах **802.6** сая төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- **Ерөө сум:** 2012 онд Бугант тосгоны Захирагчийн албаны хуучин барилгыг хүүхэд хөгжлийн төв болгох **53.8** сая төгрөгийн ажил;
- **Мандал сум:** Хүүхэд залуучуудын соёлын төвийн барилга засвар **198.0** сая төгрөг, Хэрх тосгоны соёлын төвийн их засвар **154.1** сая төгрөгийн ажил;
- **Сант сум:** ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2019 онд эхэлсэн ахмадын байрны **46.1** сая төгрөгийн ажил;

- **Сайхан сум:** Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдсэн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **36.5** сая төгрөгийн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
- **Хүдэр сум:** 2011 онд сумын ОНХО-аар хийгдсэн 20.0 сая төгрөгийн Баянцагааны гүүр, 9.5 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж дуусаагүйгээс олгосон санхүүжилтийн дүнгээр буюу **27.4** сая төгрөгөөр;
- **Жавхлант сум:** Халуун усны засварын 13.6 сая төгрөгийн ажил;
- **Хушаат сум:** ЭМТ-ийн 2014 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байсан 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гадна талын цэвэр бохир усны шугамын ажлын 80 хувийн гүйцэтгэлд 23.0 сая төгрөг олгосон боловч гүйцэтгэгч нь тухайн үед нас барснаас ажил нь дуусаагүй, сумын ЗДТГ-ын дуусаагүй барилга дансанд 2012-2018 онуудын хооронд хийгдсэн 100.1 сая төгрөгийн /мал угаалгын ванн, дуулга хорооллын цахилгааны шугам, Рашаантын хөтлийн зам, сумын төвийн камержуулалт, ногоон байгууламжийн үлдэгдэл, хорооны тохижилт, ногоо даршлах цехийн засвар, эргүүлийн пост/ зэрэг нийт **123.1** сая төгрөгийн ажлуудыг тус тус хийгдэж дуусаагүйгээс олгосон санхүүжилтийн дүнгээр орлого авч, бүртгэл тайланд тусгасан байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, улсын комиссын актаар хүлээн аваагүй, нийт **4,086.5** сая төгрөгийн барилга, замын ажил бүртгэлтэй байна. Үүнд:

- **Хушаат сум:** 2012 онд УТХО-аар хийгдсэн Соёлын төвийн 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын өргөтгөлийн ажил /олгосон **61.5** сая төгрөгийн санхүүжилтийн дүнгээр бүртгэсэн/, цэцэрлэгийн **300.0** сая төгрөгийн барилга угсралтын ажлууд;
- **Мандал сум:** 2014 онд ЗДТГ-ын дансанд бүртгэсэн сумын хөрөнгө оруулалтаар хүүхэд залуучуудын соёл, спортын цогцолбор төвийн **692.8** сая төгрөг, Тарни 8 дугаар багийн байр 2001 онд бүртгэсэн **40.0** сая төгрөг, 2018 онд бүртгэсэн сумын төвийн дотор хийгдсэн 4.7 км, **1,070.9** сая төгрөгийн асфальтан замын ажил, 2011 онд бүртгэсэн Түнхэл тосгоны **1,067.6** сая төгрөгийн, Захирагчийн алба, соёлын төвийн байр, ногоон байгууламж барих **10.8** сая төгрөг, Хэрх тосгоны 2008 оноос УТХО-аар баригдаж эхэлсэн **435.5** сая төгрөгийн эмнэлгийн барилга, Хэрх цэцэрлэгийн **188.8** сая төгрөгийн их засвар, Сумын ЗДТГ-ын засвар **118.6** сая төгрөг, Хүүхэд залуучуудын соёлын төвийн барилга **16.7** сая төгрөгийн ажлууд;
- **Жавхлант сум:** Сумын соёлын төвийн их засвар 100.0 сая төгрөг, ЭТМ-ийн их засвар 50.0 сая төгрөгийн ажлууд;
- **Түшиг сум:** 2012 онд УТХО-ын **83.3** сая төгрөгөөр хийгдсэн ЕБС-ийн дээврийн засварын ажлуудыг тус тус баримт материал, ажлын гүйцэтгэл дутуу зэргээс улсын комисс хүлээж аваагүй, үлдэгдлээр тайлагнагдсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15,829.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 21,797.0 сая төгрөг болж 5,967.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	15,585.2	20,441.7	4,856.5
Богино хугацаат зээлийн өглөг	394.8	394.8	0.0
Арилжааны банк	394.8	394.8	0.0
Өглөг	697.2	2,875.7	2,178.5
Ажилчидтай холбогдсон өглөг	183.3	200.5	17.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	24.3	43.4	19.1
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	82.3	3.7	(78.6)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	383.1	2,592.7	2,209.6
Зээлийн хүүгийн өглөг	24.2	35.4	11.2
Бусад өглөг	12,704.0	14,286.0	1,582.0
Байгууллагад төлөх өглөг	3,060.7	3,486.5	425.8
Хувь хүмүүст төлөх өглөг	12.5	29.7	17.2
Татварын өглөг /ОНӨААТҮГ/	3,287.6	2,950.7	(336.9)
НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/	2,018.2	2,701.4	683.2
Ноогдол ашгийн өглөг /ОНӨААТҮГ/	2.0	2.0	0.0
Дансны өглөг /ОНӨААТҮГ/	4,323.0	5,115.7	792.7
Урьдчилж орсон орлого	1,789.2	2,885.2	1,096.0
Урт хугацаат өр төлбөр дүн	244.3	1,355.3	1,111.0
Арилжааны банк	233.0	144.0	(89.0)
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	11.3	1,211.3	1,200.0
Дүн	15,829.5	21,797.0	5,967.5
Үүнээс: Байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	991.4	3,184.3	2,192.9
Төсөл, сан	2,151.8	2,806.7	654.9
Төрийн сан	277.9	9.5	(268.4)
ОНӨААТҮГ	12,408.4	15,796.5	3,388.1
Дүн	15,829.5	21,797.0	5,967.5

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өглөгийн 32.5 хувь буюу 7,077.2 сая төгрөгийг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ, 13.2 хувийг буюу 2,877.4 сая төгрөгийг “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ, 9.0 хувь буюу 1,970.2 сая төгрөгийг “Гавшгай ус” ХХК, 7.4 хувь буюу 1,627.9 сая төгрөгийг “Урсгал ус” ХХК эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оноос 4,856.5 сая төгрөгөөр өсөхөд хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 2,209.6 сая төгрөгөөр, дансны өглөг /ОНӨААТҮГ/ 792.7 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/ 683.2 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 425.8 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн 72.5 хувь буюу 15,796.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 14.6 хувь буюу 3,184.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 12.8 хувь буюу 2,806.7 сая төгрөгийг төсөл сангийн барьцаа

хөрөнгийн, 0.1 хувь буюу 9.5 сая төгрөгийг төрийн сангийн өр төлбөр тус тус эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдэл 1,789.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,885.2 сая төгрөг болж, 1,096.0 сая төгрөгөөр өссөн нь “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ 1,090.8 сая төгрөг, “Мандал энерго” ОНӨААТҮГ 5.2 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалсан байна.

Дансны өглөг дансны эхний үлдэгдэл 4,323.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,115.7 сая төгрөг болж, 792.7 сая төгрөгөөр өссөн нь “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 4,603.6 сая төгрөгийн, “Гавшгай ус” ХХК 253.5 сая төгрөгийн, бусад 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 276.6 сая төгрөгийн өглөгтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

Урт хугацаат зээлийн өр төлбөр оны эцэст 1,111.0 сая төгрөгөөр өссөн нь “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын хөрөнгө оруулалтын гурвалсан гэрээгээр авсан 1,200.0 сая төгрөгийн зээлээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөрийн данстай холбоотой нийт 82.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт №2-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй ба төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 13 байгууллага **43.8** сая төгрөгийн төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй 6 байгууллагын **7.9** сая төгрөгийн өр төлбөрийг тайлант оны төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан,
- Зүүнбүрэн сумын ЭМТ хэрэгцээнээс илүү **31.1** сая төгрөгийн эм боох материалыг зээлээр авч, нөөцөлснөөс өр төлбөр үүсгэсэн байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 264,548.6 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 281,816.7 сая төгрөг болж, 17,268.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/ /сая төгрөг/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,503.4	82,004.2	(7,499.2)
Өмч /төрийн/ /ОНӨААТҮГ/	527.6	2,600.3	2,072.7
Эздийн өмчийн бусад хэсэг /ОНӨААТҮГ/	993.1	6,579.1	5,586.0
Хуримтлагдсан үр дүн	45,964.8	62,983.3	17,018.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,315.0	126,970.8	(344.2)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	244.7	679.1	434.4

Дүн	264,548.6	281,816.8	17,268.2
Төсөвт байгууллага	189,029.8	201,088.1	12,058.3
Төсөл, сан	217.6	217.2	(0.4)
Төрийн сан	2,146.4	5,866.5	3,720.1
ОНӨААТҮГ	73,154.8	74,645.0	1,490.2
Дүн	264,548.6	281,816.8	17,268.2

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 281,816.8 сая төгрөг болж өмнөх оноос 17,268.2 сая төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 12,246.6 сая төгрөгөөр тайлагнасан нь голлон нөлөөлсөн бөгөөд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Засгийн газрын оруулсан капитал өмнөх оноос 7,499.2 сая төгрөгөөр буурсан нь Сүхбаатар сумын “Хаданхүй, “Зөвлөх” өрхийн эмнэлгүүдийг татан буулгасан 78.8 сая төгрөг, “Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ, “Сүхбаатар ТҮГ”-т бүтцийн өөрчлөлт хийж, үндсэн хөрөнгийг шинээр байгуулагдсан “Сүхбаатар хөгжил, тохижилт” ОНӨААТҮГ-т шилжүүлсэн 7,149.5 сая төгрөг зэргээс голлон шалтгаалсан байна
- Орон нутгийн өмч урьд оноос өссөн нь “Сэлэнгэ хөгжил тохижилт” ОНӨААТҮГ нь “Сэлэнгэ үйлчилгээ”, “Сүхбаатар ТҮГ”-аас 2,198.5 сая төгрөгийн хөрөнгө, 5,454.8 сая төгрөгийн эздийн өмчийн бусад хэсгийг шилжүүлэн авснаас голлон шалтгаалсан байна.
- Сүхбаатар сумын 2-р сургууль 2.9 сая төгрөг, өрхийн эмнэлэг 8.1 сая төгрөг, Сайхан сумын 1, 2, 3-р цэцэрлэгүүдэд нийт 10.8 сая төгрөг, Цагааннуур сумын 1-р цэцэрлэг 0.1 сая төгрөг, Дулаанхаан тосгоны Захирагчийн алба 75.3 сая төгрөг, 3-р сургууль 247.0 сая төгрөгийн хөрөнгүүдийг акталж, шилжүүлсэн зэргээс голлон шалтгаалж хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү нийт 344.2 сая төгрөгөөр буурсан байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 8 ТТЗ-ийн 26 байгууллагын өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой нийт 411.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт №10. Залруулга хийгдсэн байгууллагын судалгаа

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Дүн	№	Байгууллагын нэр	Дүн
1	Аймгийн орон нутгийн ерөнхий орлого	325.7	14	Мандал сумын ЭМТ	(8.6)
2	Аймгийн ОНХС	(30.2)	15	Цагааннуур сумын цэцэрлэг	0.1
3	Урсгал ус ХХК	(118.0)	16	Баянгол сумын СХСан	(2.2)
4	Гавшгай ус ХХК	6.4	17	Баянгол сумын ЕБС	(1.7)
5	Цант орхон ХХК	(0.6)	18	Сайхан сумын 24-р цэцэрлэг	7.9
6	Мандал энерго ОНӨААТҮГ	(24.1)	19	Сайхан сумын 11-р цэцэрлэг	1.9
7	Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ	1,998.5	20	Сайхан сумын 11-р цэцэрлэг	1.0
8	Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ	(1,474.9)	21	Шаамар сумын Захирагчийн алба	75.4
9	ГХБХБГазар	(0.1)	22	Хүдэр сумын ЗДТГ	(77.4)

10	Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт	(3.7)	23	Сүхбаатар сумын Өрхийн эмнэлэг	(25.0)
11	Мандал сумын СХС	(4.3)	24	Сүхбаатар сумын ТҮГ	(537.8)
12	Мандал сумын Хэрх сургууль	52.3	25	Сүхбаатар сумын 2-р сургууль	2.8
13	Мандал сумын 1-р сургууль	0.8	26	Сүхбаатар сумын 3-р сургууль	247.0
				Нийт дүн	411.2

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой материаллаг хэмжээний залруулгыг тодруулбал:

- Сангийн яамнаас ирсэн зөвлөмжийн дагуу аймгийн ерөнхий орлогын дансны засгийн газрын оруулсан капиталын дүнг 325.7 сая төгрөгөөр бууруулж, хуримтлагдсан үр дүнг мөн дүнгээр нэмэгдүүлсэн,
- “Сэлэнгэ үйлчилгээ”, “Сүхбаатар ТҮГ” зэрэг байгууллагуудыг нэгтгэж “Сэлэнгэ хөгжил тохижилт” ОНӨААТҮГ байгуулан, данснаас дансанд бүх хөрөнгө, өр төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 1,998.5 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэн, “Сүхбаатар ТҮГ” нь 537.8 сая төгрөг, Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ нь 1,497.0 сая төгрөгөөр тус тус хуримтлагдсан үр дүнг бууруулсан,
- Сүхбаатар сумын 3-р сургууль нь МСҮТ-д шилжүүлсэн 2 барилгын дахин үнэлгээний дүн болох 247.0 сая төгрөгийг шилжигдээгүй үлдсэн байсныг залруулж, хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 0,7-1,475.4 сая төгрөг, нийт 4.433.7 сая төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадаагүй байна.

3.5.9 Орлогын данс

Тайлант онд орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 211.4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 270.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан буюу 28 хувиар давж биелсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын данстай холбоотой нийт 2,802.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ХХОАТ-ыг үндэслэлгүй нэмэгдүүлэн тодотгосноос аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2,534.4 сая төгрөгөөр тасалсан,
- Мандал сумын Билэг ДБ хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийн орлогыг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр бус батлагдсан төсвөөр тооцон 60.4 сая төгрөгийг илүү шилжүүлсэн,
- Орон нутгийн төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах тухай сумын ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр Жавхлант сум 2.2 сая төгрөг,

Зүүнбүрэн сум 3.5 сая төгрөг, Орхонтуул сум 28.3 сая төгрөг, Түшиг сум 9.7 сая төгрөг зэрэг нийт 43.7 сая төгрөгийг зарцуулсан,

- Хушаат сум төсвийн орлогод төвлөрүүлэх бэлчээрийн төлбөрийн 12.6 сая төгрөгийг Мөнх толгойн хөгжил, Даагат хөгжил сангийн дансанд төвлөрүүлсэн,
- Сант сум төсөвт төвлөрүүлэх 1.2 сая төгрөгийн хадлангийн төлбөрийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан,
- Алтанбулаг сум нь аймгийн Онцгой комиссоос олгосон санхүүгийн дэмжлэг, тусгаарлагдсан иргэдийн тусгаарлах байрны төлбөрийн орлого 45.2 сая төгрөг, Алтанбулаг сум үүсэж хөгжсөний 290 жилийн ойд БНХАУ-ын элчин сайдын яамнаас хандивласан 40.0 сая төгрөг зэрэг нийт 85.2 сая төгрөгийг ТББ-ын дансанд төвлөрүүлж, зарцуулсан.
- “Сүхбаатар хөгжил, тохижилт” ОНӨААТҮГ лангууны түрээсийн 13.2 сая төгрөг, “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь орон сууцны сарын хуваарьт төлбөрийн 52.1 сая төгрөг зэрэг нийт 65.3 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,

3.5.10 Зардлын данс

Зардлын данстай холбоотой нийт **1,226.0** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

1. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах **433.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:**

- Аймгийн ИТХ-д суудалтай намуудад хууль, эрхийн актад нийцээгүй **180.0** сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлуулж, хэрэгжүүлсэн,
- Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас 4.6 сая төгрөгийн гадаад томилолтын зардал, ЗДНХ-өөс аймгийн ЗДТГ-ын ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 3.5 сая төгрөг, удирдах ажилтны зөвлөгөөнд 6.5 сая төгрөг, нийт 10.0 сая төгрөгийг ЗДТГ-ын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан зэрэг нийт **14.6** сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг сурталчилсан 33.5 сая төгрөгийн өртөг бүхий “Он дарааллын бичээс” сэтгүүл, Ковид-19 цар тахалтай холбогдуулан аймгийн Онцгой комисст иргэд, ААНБ-аас хандивласан 26.4 сая төгрөг зэрэг нийт **59.9** сая төгрөгийг бүртгэл, тайланд тусгаагүй,
- ЗДНХ-ийн төсвөөс хэлтэс агентлагийн болон сумдын Засаг дарга нарт бэлэг дурсгал болгох мөнгөн аяга худалдан авахад **17.3** сая төгрөг зарцуулж, худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн ,
- ЗДҮАХ-ийн батлагдсан төсвөөс аймгийн ЭМГ-т шилжүүлсэн 8.8 сая төгрөг, ЗДНХ-ийн төсвөөс аймгийн Нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн 17.0 сая төгрөг, Ерөө сумын ЗДТГ-т шилжүүлсэн 1.0 сая төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан 11.8 сая төгрөг зэрэг нийт **38.6** сая төгрөгийн ажил гүйлгээ нь анхан шатны баримтаар бүрэн

нотлогдохгүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,

- Сургуулиудын урсгал зардлаас тавилга, эд хогшил худалдан авах зардалд төсвийн зохицуулалтыг төсвийн жилийн эцэст буюу 12 дугаар сарын 19-нд хийж, 13 сургуульд нийт **122.6** сая төгрөгийн өртөг бүхий сурагчийн ширээ сандал худалдан авсан боловч нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор нийт өртгийг сургууль тус бүрийн төсөвт хуваан Смарт солюшн фурничур, Би Си Ти, Медикал гэсэн 3 компаниас шууд худалдан авалт хийсэн.

2. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад нийт **793.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

2.1 Цалин, урамшуулал, тусламжтай холбоотой нийт **125.7** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт №3-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэргүйгээр буюу давхардуулан олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон зэргээр 82 байгууллага **98.0** сая төгрөгийн зөрчил гаргасан,
- Батлагдсан орон тоог хэтрүүлж 6 байгууллага **21.1** сая төгрөгийн цалин олгосон,
- Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож 4 байгууллага **6.6** сая төгрөг илүү олгосон,

2.2 Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан **174.7** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт №4-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр 47 байгууллага **124.1** сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, 13 байгууллага **50.6** сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.3 Зардлын данстай холбоотой бусад **491.0** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт №5-д дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журмыг зөрчин 10 байгууллага **440.8** сая төгрөгийн худалдан авалт хийсэн,
- Эмийн батлагдсан төсөв хэтрүүлсэн, эм дутагдуулсан, дутагдсан эмийг зардалд тайлагнасан, эмийн борлуулалтын орлогыг дутуу төвлөрүүлсэн зэргээр 11 байгууллага **50.2** сая төгрөгийг зөрчил гаргасан,

2.4 Аймгийн ИТХ, Хүдэр сумын ИТХ нь батлагдсан төсвөөс нийт **1.6** сая төгрөгийн хандив өгсөн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймаг, сумдын 2020 оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 29,527.7 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 30,661.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 3.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №11. Аймаг, сумдын төсвийн орлого

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2020 он							
	Аймаг		Сумд		Нийт орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал орлого	20,566.3	17,979.8	8,931.4	12,599.9	29,497.7	30,579.7	1,082.0	103.7
Татварын орлого	19,599.3	17,220.8	7,522.6	10,078.1	27,121.9	27,298.9	177.0	100.7
Хувь хүний орлогын албан татвар	17,369.9	13,820.3	1,899.3	2,676.0	19,269.2	16,496.3	(2,772.9)	85.6
ХХОАТ-ын буцаалт	(972.1)	(968.0)	-	-	(972.1)	(968.0)	4.1	99.6
Өмчийн татвар	1,099.0	1,309.6	662.3	748.2	1,761.3	2,057.8	296.5	116.8
Бараа үйлчилгээний татвар	2,102.5	3,058.9	4,961.0	6,653.9	7,063.5	9,712.8	2,649.3	137.5
Татварын бус орлого	967.0	759.0	1,408.8	2,521.8	2,375.8	3,280.8	905.0	138.1
Хөрөнгийн орлого	30.0	82.1	-	-	30.0	82.1	52.1	273.7
НИЙТ ОРЛОГО	20,596.3	18,061.9	8,931.4	12,599.9	29,527.7	30,661.8	1,134.1	103.8

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 3,668.5 сая төгрөгөөр давж биелсэн боловч аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,534.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн нийт орлогын дүнгээр хувь хүний орлогын албан татварын төлөвлөгөө 2,802.9 сая төгрөгөөр тасарч, өмчийн татвар 296.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний татвар 2,649.8 сая төгрөгөөр, татварын бус орлого 905.0 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Давж биелсэн орлогууд:

- **Бараа үйлчилгээний татвар:** Мандал, Ерөө, Хүдэр зэрэг сумдад хуш модны самрын нөөц тогтоогдож, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар самар түүх иргэн, ААНБ-уудын тоо нэмэгдсэнээс шалтгаалан ойн нөөц ашигласны төлбөрийн орлого давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.
- **Өмчийн татвар болон татварын бус орлого:** Төрийн албаны “Хур” системд шилжсэн, татварын албаны программд нэхэмжлэл үүсгэсний дагуу

үл хөдлөх хөрөнгө, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар, газрын төлбөр, хүү торгуулийн орлого, бусад орлогыг иргэн, ААНБ-ын үндсэн харьяаллаар нь тухайн орон нутагт төвлөрүүлдэг болсноос голлон шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- **Хувь хүний орлогын албан татвар:** Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд аж ахуйн нэгжүүдийг ХХОАТ-аас чөлөөлсөн атал аймгийн ИТХ-ын 2020 оны 9 сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолоор аймгийн ХХОАТ-ын төлөвлөгөөг 1,699.9 сая төгрөгөөр нэмж тодотгосноос шалтгаалж нийт дүнгээр 2,802.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Сэлэнгэ аймгийн 2020 оны төсвийн суурь орлогыг 17,516.0 сая төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 5,579.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 8,141.2 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 590.9 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 56,972.9 сая төгрөгөөр буюу нийт 88,800.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр хянаж ирүүлсэн байна.

Сангийн яам, УИХ-аас хянагдаж батлагдсан аймгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоолоор газрын төлбөрийн орлогыг 80.0 сая төгрөгөөр, ХХОАТ-ын орлогыг 700.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр, урьд оны мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 1,823.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр тооцож, нийт орлогыг 91,404.1 сая төгрөг болгож, нэмэгдүүлэн баталсан байна.

УИХ-ын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталсан 2020 оны төсвийн тодотголоор Сэлэнгэ аймгийн орон нутгийн суурь орлогыг 500.0 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 1,572.4 сая төгрөгөөр, нийт 2,072.4 сая төгрөгөөр бууруулан, баталж ирүүлсэн байна.

УИХ-аар баталсан аймгийн 2020 оны тодотгосон төсвийн орлогыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолоор ХХОАТ-ыг 2,227.8 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 120.0 сая төгрөгөөр зэрэг нийт 2,347.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 319.6 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 401.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 851.1 сая төгрөгөөр, урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,530.0 сая төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, аймгийн 2020 оны төсвийн нийт орлогыг 91,551.0 сая төгрөгөөр баталсан байна.

Сумдын 2020 оны төсвийн нийт орлогыг 11,047.1 сая төгрөгөөр, СХС-ийн орлогыг 1,952.5 сая төгрөгөөр баталснаар аймаг, сумдын төсвийн нийт орлогыг 104,550.6 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 65 хөтөлбөрт зориулан 104,550.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 89,242.6 сая төгрөгийг урсгал зардалд, 13,355.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 1,902.9 сая төгрөг, бараа, үйлчилгээний зардалд 49.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 56,121.7 сая төгрөгийг ТЗШ-ээс, 42,526.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 590.9 сая төгрөгийг ЭМД-ын сангаас, 214.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 2,284.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 860.0 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивын орлогоос, 1,952.5 сая төгрөгийг СХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 52,057.8 сая төгрөгийг ТЗШ-ээс, 39,272.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 440.1 сая төгрөгийг ЭМД-ын сангаас, 247.9 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 848.0 сая төгрөгийг хандивын орлогоос, 904.3 сая төгрөгийг СХС-ын зээлийн эргэн төлөлтөөс зэрэг нийт 93,770.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 91,576.6 сая төгрөг буюу 87.6 хувьтай тайлагнагдсан нь ЭМД-ын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 1,766.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,092.6 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 95.2 сая төгрөгөөр, нормативт зардал 2,184.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 227.3 сая төгрөгөөр, томилолтын зардал 55.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 289.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 703.1 сая төгрөг, төрийн өмчит байгууллагад олгох татаас 11.4 сая төгрөг, урсгал шилжүүлэг 677.3 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд 13,355.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 8,702.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 4,653.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 204.2 сая төгрөг, ЗДНХ-өөс 501.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 3,019.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,150.0 сая төгрөг, нийт 5,875.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 263.6 сая төгрөг, НДШ-д 16.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 19.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 96.1 сая төгрөг, нормативт зардалд 959.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 198.2 сая төгрөг, томилолт, зочны зардалд 7.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 377.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,407.9 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 1,709.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 444.3 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлд 14.0 сая төгрөг зэрэг нийт 5,512.7 сая төгрөгийг зарцуулж, 362.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 152 мэдээллээс 49 мэдээллийг хугацаанд нь, 14 төрлийн 103 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Хугацаа хоцроосон 103 мэдээллийг харуулбал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл-12 удаа,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт-1 удаа,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-11 удаа,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт-6 удаа,
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл-11 удаа,
- Санхүүгийн тайлан-1 удаа,
- Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл-10 удаа,
- Батлагдсан төсөв-1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл-13 удаа,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн

ерөнхий мэдээлэл-8 удаа,

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг-10 удаа,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр-7 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт-5 удаа,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн-7 удаа.

Аудитад хамрагдаж, бие даасан дүгнэлт гаргасан харьяа 100 байгууллага шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 14,373 мэдээллээс 11,945 мэдээллийг хугацаанд нь, 2,285 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 141 мэдээллийг огт мэдээлээгүй, Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг, Сэлэнгэ баялаг ирээдүй, Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ууд шилэн дансны цахим хуудсанд цэс нээгээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №6-д харуулав./

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 4.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа, зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №12. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Биелэлтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	4.4	1	4.4	-	-	100
Албан шаардлага	2	-	2	-	-	-	100
Зөвлөмж	3	-	2	-	1	-	66.6
Нийт	6	4.4	5	4.4	-	-	83.3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар өгсөн “Засгийн газрын тогтоолоор баталсан дүрмийг хэрэгжүүлэн, дотоод хяналт шалгалтын удирдамжийг ТЕЗ-аар батлуулж, хийсэн хяналт, шалгалтын дүнг Дотоод аудитын хороонд тайлагнаж байх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй учир уг зөрчилд албан шаардлага бичигдэв.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 сумын төвлөрүүлэн захирагч, 220 төсвийн байгууллага, 16 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 253 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 226 байгууллагыг аудитад хамруулан, 27 байгууллагад МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 226 байгууллагаас 126 байгууллагыг түүвэрт хамруулж, 100 байгууллагад бие даасан дүгнэлт хүргүүлээ. Үүнд: 77 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 21 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн бол 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

Хүснэгт №13. Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байгууллагууд:

№	Байгууллагын нэрс	№	Байгууллагын нэрс
1	Алтанбулаг сумын ТТЗ	12	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ
2	Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг	13	Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ
3	Баянгол сумын цэцэрлэг	14	Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ
4	Ерөө сумын ТТЗ	15	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ
5	Ерөө сумын ЗДТГ	16	Урсгал ус ХХК
6	Зүүнбүрэн сумын ТТЗ	17	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ
7	Орхонтуул сумын ТТЗ	18	Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ
8	Сант сумын ЗДТГ	19	Мандал энерго ОНӨААТҮГ
9	Хушаат сумын ТТЗ	20	Туулын хишиг ОНӨААТҮГ
10	Байгаль орчин аялал, жуулчлалын газар	21	Гавшгай-Ус ХХК
11	Сэлэнгэ ҮЦСАА ОНӨААТҮГ		

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын Санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэл

Ихээхэн буюу түгээмэл материаллаг зөрчлийн нөлөөллийн улмаас Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “**Сөрөг**” санал дүгнэлт өгсөн бөгөөд материаллаг зөрчлийн улмаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн “Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, тодруулгад дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,811.6 сая төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлснээс 783.8 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 60.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 2,967.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн нийт **783.8** сая төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөг, авлагын тодруулгад 406.2 сая төгрөгийн авлага, 377.6 сая төгрөгийн өглөгийн насжилтыг зөрүүтэй нэгтгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

1. Мандал сумын Билэг ДБ хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр бус батлагдсан төсвөөр тооцон **60.4** сая төгрөгийг илүү шилжүүлсэн нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь “... *ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.*”, Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 4.5 дахь “*Хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар ... сар бүр хүүхэд өдрөөр хянаж, ... улирал тутам олгоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн хувьсах зардлын санхүүжилтийг 2021 оны батлагдсан төсвөөс суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд 4806 аж ахуйн нэгж, байгууллагыг ХХОАТ-аас чөлөөлсөн атал аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолоор ХХОАТ-ын төлөвлөгөөг 2,227.8 сая төгрөгөөр нэмж тодотгосноос голлон шалтгаалж, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг **2,534.4** сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “*Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1: хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*” гэсэн заалтыг зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогыг бодитоор төлөвлөн, төлөвлөгөөг бүрэн биелүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д тусгасан “ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг” гэсэн ангиллыг үндэслэн аймгийн ИТХ-д суудал бүхий намын санхүүжилтэд **180.0** сая төгрөг төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь “УИХ-д суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор УИХ-ын гишүүний нэг суудлыг жилд 10 сая төгрөгөөр тооцож, УИХ-ын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно” гэж заасантай нийцээгүй ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгаж, батлуулахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4. Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас 4.6 сая төгрөгийн гадаад томилолтын зардал, ЗДНХ-өөс аймгийн ЗДТГ-ын ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 3.5 сая төгрөг, удирдах ажилтны зөвлөгөөнд 6.5 сая төгрөг, нийт 10.0 сая төгрөгийг ЗДТГ-ын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан зэрэг нийт **14.6** сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, аймгийн Засаг даргын 2017 оны А/543 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан “Аймгийн ЗДҮАХ, АХХ-ийг хангах зардлыг зарцуулахад дагаж мөрдөх журам”-ын 2, 3 дугаар хэсэгт заасныг тус тус зөрчсөн бөгөөд “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сурталчилж, тайлагнасан **33.5** сая төгрөгийн “Он дарааллын бичээс” сэтгүүл болон Ковид-19 цар тахалтай холбогдуулан аймгийн Онцгой комисст иргэд, ААНБ-аас өгсөн **26.4** сая төгрөгийн хандивыг бүртгэл, тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5. бүх орлого, 14.4.6. бүх зардал” гэсэн заалтыг зөрчсөн ба “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого, зарлагыг бүртгэл тайланд бүрэн тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

6. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс хэлтэс агентлагийн болон сумдын Засаг дарга нарт бэлэг дурсгал болгох мөнгөн аяга худалдан авахад **17.3** сая төгрөг зарцуулж, худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн

газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг*” гэсэн гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэх.

7. ЗДҮАХ-ийн зардлаас аймгийн ЭМГ-т шилжүүлсэн 8.8 сая төгрөг, ЗДНХ-ийн төсвөөс аймгийн Нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн 17.0 сая төгрөг, Ерөө сумын ЗДТГ-т шилжүүлсэн 1.0 сая төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан 11.8 сая төгрөг зэрэг нийт **38.6** сая төгрөгийн ажил гүйлгээ нь Засаг даргын захирамж, хурлын тэмдэглэл, төсвийн зардлын дэлгэрэнгүй тооцоо, эмнэлгийн хэрэгслийг хүлээлгэн өгсөн комиссын акт зэрэг анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.3 дахь заалтуудтай нийцээгүй ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

8. Сургуулиудын урсгал зардлаас тавилга, эд хогшил худалдан авах зардалд төсвийн зохицуулалтыг төсвийн жилийн эцэст буюу 12 дугаар сарын 19-нд хийж, 13 сургуульд нийт **122.6** сая төгрөгийн өртөг бүхий сурагчийн ширээ сандал худалдан авсан боловч нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор нийт өртгийг сургууль тус бүрийн төсөвт хуваан Смарт солюшн фурничур, Би Си Ти, Санус медикал гэсэн 3 компаниас шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- *Сүхбаатар сумын 5 дугаар сургуульд 7.5 сая төгрөг,*
- *Баруунбүрэн сумын боловсролын сургуульд 9.5 сая төгрөг,*
- *Алтанбулаг, Баянгол, Орхон, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр, Шаамар сумдын 11 сургуульд тус бүр 9.6 сая төгрөгөөр буюу нийт 105.6 сая төгрөг.*

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь “*Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.*”, 8.4 дэх “*Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл*

болгоно”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1 дэх *“Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 50.0 сая төгрөг”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэх.

9. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 103 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.8, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд *“Үнэн зөв байдал”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

10. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагч батлаагүй, хяналт шалгалтын дүнг Дотоод аудитын хороонд тайлагнуулж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д *“Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлыг дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, тайлагнана”*, 7.6.1-д *“Гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн”* гэж заасантай нийцээгүй ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналт шалгалтын удирдамжийг ТЕЗ батлах, хийсэн хяналт, шалгалтын дүнг Дотоод аудитын хороонд тайлагнуулж, үнэлэлт дүгнэлт өгч байх албан шаардлага хүргүүлэх.

11. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ, Урсгал ус, Гавшгай ус ХХК –иуд шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн, Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь орон сууцны төлбөрийн орлогыг хуваарийн дагуу төвлөрүүлээгүй зэрэг зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар:

Нийт 17 сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийснээс 11 сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Хушаат зэрэг 5 сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд

“Хязгаарлалттай”, Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,979.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,524.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 55.1 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт, 662.6 сая төгрөгийн зөрчилд 72 албан шаардлага, 10 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, 737.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 90 зөвлөмж өглөө.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Харьяа төсвийн 67 байгууллагаас 62 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг, Баянгол сумын цэцэрлэг, Ерөө сумын ЗДТГ, Сант сумын ЗДТГ, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг 5 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 861.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 327.3 сая төгрөгийн алдааг залруулж, 47.1 сая төгрөгийн зөрчилд 43 төлбөрийн акт тогтоон, 189.2 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 298.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 104 зөвлөмж өглөө.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Орон нутгийн өмчит 16 аж ахуйн нэгжийг аудитад хамруулснаас 4 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 11 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, ТЭДДҮТТөв ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

Аудитаар нийт 3,361.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,579.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоон, 546.4 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 233.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 35 зөвлөмж өглөө.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

3.10.1 33,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Он дарааллын бичээс 2016-2019 сэтгүүл хэвлэх” худалдан авах ажиллагааг цахимаар зарлаж, Сэлэнгэ принтинг ХХК 33,500.0 мянган төгрөг, Сэлэнгэ пресс ХХК 29,260.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн байна.

Техникийн тодорхойлолтод “2016-2019 онд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний талаарх зураг дүрс гэх мэт дижитал технологид суурилсан архивын мэдээллийн баазтай байх”, “Сэлэнгэ аймгийн төрийн байгууллагад өмнө нь хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай” гэх мэт хэт 1 талыг барьсан буюу байнгын харилцагч Сэлэнгэ принтинг компанид чиглэсэн шалгуурыг тусгасан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн

6 дугаар зүйлийн 6.1 дэх “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Цаашид тайлан, сэтгүүл хэвлүүлэх зардлын төсөвт өртгийг аж ахуйн нэгжүүдээс үнийн судалгаа авсны үндсэн дээр тогтоох, худалдан авах ажиллагаанд ил тод, тэгш өрсөлдөх боломжийг хангаж, нэг талд хэт давуу байдал олгох шалгуурыг техникийн тодорхойлолтод тусгахгүй байх нь зүйтэй юм.

3.12.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан нийт авлагын 47.7 хувь буюу 7,334.9 сая төгрөгийг аймаг хөгжүүлэх сангаас /хуучин нэрээр/ олгож Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ-т шилжүүлсэн 2,660.8 сая төгрөгийн зээл болон сумдын СХС-гаас олгосон 4,674.1 сая төгрөгийн зээл эзэлж байна.

Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэхээр шүүх, шүүхийн шийдвэрийн байгууллагад хандаж, ажиллаж байгаа боловч Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ-т 61 иргэн, 22 ААНБ-д холбогдох 2,660.8 сая төгрөг, сумдын СХС-ийн 3,105.7 сая төгрөг зэрэг нийт 5,766.5 сая төгрөгийн зээл нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь сангийн хөрөнгийн эх үүсвэрийн эргэц удааширч, үр өгөөж буурах, найдваргүй зээлийн авлагын үлдэгдэл өсөх эрсдэлтэй тул эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлд дүн шинжилгээ хийж, гэрээний дагуу хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж, барагдуулах арга хэмжээг зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Хуримтлагдсан үр дүнгийн данстай холбоотой асуудал:

4.1.1 Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгж нь тус бүр 0.1-2,761.1 сая төгрөгийн авлага, 0.1-7,221.2 сая төгрөгийн өр төлбөр зэрэг нийт 7,231.9 сая төгрөгийн авлага, 15,772.5 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан, үйл ажиллагааны үр дүнгээр 11 ОНӨААТҮГ нь тус бүр 0.7-1,475.4 сая төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам авлага, өр төлбөр, алдагдлын хэмжээ нэмэгдэж байна. /Хавсралт №7-д дэлгэрэнгүй харуулав./

4.1.2 Эрсдэл: Үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болох, санхүүгийн эх үүсвэр дутагдах.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ ...” тодорхойлолттой

нийцэхгүй байгаа тул орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийх замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа нь тогтворжоогүй аж ахуйн нэгжүүдийг татан буулгах арга хэмжээ авах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

4.2 Бараа материалын данстай холбоотой асуудал:

4.2.1 Илрүүлэлт: Бараа материалын тайланд материалыг орлого хүлээн авсан хэмжээгээр зарцуулсан гэж бүртгэлд тусгадаг, анхан шатны баримтыг үндэслэн тайлан гаргадаггүй, үлдэгдлийг тоолж, агуулахын бүртгэлтэй тулгадаггүйгээс бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн, жилийн эцсийн тооллогоор агуулахын үлдэгдлийг тоолоогүй зэрэг зөрчил аймгийн ЗДҮАХ, ЗДНХ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд нийтлэг байдлаар оршиж байна.

4.2.2 Эрсдэл: Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчигдөх, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 9 дүгээр зүйл Бараа материалын тайлан НХМаягт БМ-9-т *"Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь ААНБ-ын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул бараа материалын тайланг баталсан маягт, аргачлалын дагуу хөтлөх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Сэлэнгэ аймгийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021.04.20			СЭА-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Сэлэнгэ аймгийн ТЕЗ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр бус батлагдсан төсвөөр тооцон илүү шилжүүлсэн.	60.4	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
2	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан.	2,534.4	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
3	Аймгийн ИТХ-д суудалтай намуудад санхүүжилт олгохоор батлуулж, хэрэгжүүлсэн.	180.0	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
4	ЗДХХХ, ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс зориулалт бусаар зарцуулсан.	14.6	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
5	Хүлээн авсан сэтгүүл, хандивыг бараа материалын болон санхүүгийн тайланд тусгаагүй .	59.9	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
6	Шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн.	17.3	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
7	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	38.6	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
8	Сургуулиудын урсгал зардлаас 13 сургуульд сурагчийн ширээ сандал худалдан авсан боловч нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор нийт өртгийг сургууль тус бүрийн төсөвт хуваан, шууд худалдан авалт хийсэн.	122,6	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
9	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 103 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.		Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
10	Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагч батлаагүй, хяналт шалгалтын дүнг Дотоод		Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр

	аудитын хороонд тайлагнуулж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй.				
11	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 4 ОНӨААТҮГ-ын даргад сахилгын шийтгэл ногдуулах.		Албан шаардлага	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
12	Орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 0.7-1,475.4 сая төгрөгийн, нийт 4,433.7 сая төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж ажиллаагүй.		Зөвлөмж	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
13	Бараа материалын тайланг анхан шатны баримтыг үндэслэн гаргадаггүй, үлдэгдлийг тоолж, агуулахын бүртгэлтэй тулгадаггүйгээс бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн.		Зөвлөмж	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга	Ш.Оргил О.Мөнхбаяр
Дүн		3,027.8			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/07

Сүхбаатар

Аудитын тайлан, дүнг батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, 37 дугаар зүйлийн 37.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитаар илрүүлсэн зөрчил, өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хавсралт 1-ээр, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн зөрчлийг хавсралт 2-оор тус тус баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлж, www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

4. “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

018010016

C:\Users\DELL\Desktop\Bichig hereg\Tushaal 2021.docx

2021 оны 04 дугаар сарын 20 өдрийн
 Дарга, тэргүүлэх аудиторын
 дугаар тушаалын хавсралт 1



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

№	Төлбөр зөрчлийн утга	Нийт зөрчлийн дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	Хувийн сургуулийн хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр бус батлагдсан төсвөөр тооцон илүү шилжүүлсэн.	60.4	60.4		
2	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан.	2,534.4		2,534.4	
3	Аймгийн ИТХ-д суудалтай намуудад санхүүжилт олгохоор батлуулж, хэрэгжүүлсэн.	180.0		180.0	
4	ЗДХХХ, ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс зориулалт бусаар зарцуулсан.	14.6		14.6	
5	Хүлээн авсан сэтгүүл, хандивыг бараа материалын болон санхүүгийн тайланд тусгаагүй.	59.9		59.9	
6	Шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн.	17.3		17.3	
7	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	38.6		38.6	
8	Сургуулиудын урсгал зардлаас 13 сургуульд сурагчийн ширээ сандал худалдан авсан боловч нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор нийт өртгийг сургууль тус бүрийн төсөвт хуваан, шууд худалдан авалт хийсэн.	122.6		122.6	
9	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 103 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.			Албан шаардлага хүргүүлэх	
10	Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагч батлаагүй, хяналт шалгалтын дүнг Дотоод аудитын хороонд тайлагнуулж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй.			Албан шаардлага хүргүүлэх	
11	Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 4 ОНӨААТҮГ-ын даргад сахилгын шийтгэл ногдуулах.			Албан шаардлага хүргүүлэх	

12	Орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны үр дүнгээр тус бүр 0.7-1,475.4 сая төгрөгийн, нийт 4,433.7 сая төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж ажиллаагүй.				Зөвлөмж өгөх
13	Бараа материалын тайланг анхан шатны баримтыг үндэслэн гаргадаггүй, үлдэгдлийг тоолж, агуулахын бүртгэлтэй тулгадаггүйгээс бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн.				Зөвлөмж өгөх
Нийт дүн		3,027.8	60.4	2,967.4	

2021 оны 04 дүгээр сарын 20 өдрийн
 Дарга, тэргүүлэх аудиторын
 дугаар тушаалын хавсралт 2



НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

/ сая төгрөг/

№	Төлбөр, зөрчлийн утга	Нийт зөрчлийн дүн	Албан шаардлага
1	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлсэн, хуулиар тогтоосон хувь хэмжээгээр хэрэгждэг БХНСАХ-ний зардлыг бууруулахаар зэрэг хууль, эрх зүйн актыг зөрчсөн тодотгол хийсэн.	744.0	744.0
2	Биеийн тамир, спортын байгууллагуудын өөрийн орлогыг санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгалгүй нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулах эрх олгосон.	28.1	28.1
Нийт дүн		772.1	772.1